

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХҮНИЙ ЭРХ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГЭРЭЭ ХЭЛЦЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
БАДРАЛЫН НОМИН-ЭРДЭНИЙ 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5
Зорилт 1. НЭГ. “ОРОН НУТАГТ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ, НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ АЛБАДАД ЧИГЛЭЛ ӨГЧ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 1.1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хууль тогтоомж, журамд заасны дагуу тухай бүр мэдээллээр хангах, тайлагнах	Мэдээ тайлан хүргүүлсэн тоо	2	1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар зарлигаар “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын батлагдсан. Тус журмын дагуу 2025 оны хагас жилийн тайлан мэдээг нэгтгэн боловсруулж 2025 оны 07 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэхээр бэлтгэж байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 14/03 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн түвшинд үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”-ийг батлуулан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2025.01.02-2025.06.05	100%

2	Арга хэмжээ 1.2. Иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад хууль сурталчилах чиглэлээр сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан иргэдийн тоогоор	30	10	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар зарлигаар “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хүрээнд тайлан мэдээ мэдээллэдэг тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудад сургалт авахаар ҮАБЗ-ийн ажлын алба, ҮАБЗ-ийн Стратеги, судалгааны хүрээлэнд албан бичиг хүргүүлсэн.	2025.01.02-2025.06.05	100%
3.	Арга хэмжээ 1.3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмж шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	2	1	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс эхний хагас жилд 3 зөвлөмж, чиглэл ирсэн. Үүний дагуу тухай бүр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ҮАБЗ-ийн ажлын албанд хэрэгжүүлсэн ажлын талаар хариу мэдээллэж ажилласан. Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан ҮАБЗ-ийн ажлын албанаас орон нутагт ҮАБ-ыг хангах бодлого хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах чиглэл ирсэн. Үүнтэй холбогдуулан 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 03 дугаар улирлын ИТХ-ын хуралдаанаар шинэчлэн батлуулахаар төлөвлөсөн. Хөтөлбөрийг байнгын ажиллагаатай ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж шинэчлэн боловсруулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	2025.01.02-2025.06.05	100%

Зорилт 2. ЗАХИРГААНЫ ГЭРЭЭГ ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦҮҮЛЭН БАЙГУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

4	Арга хэмжээ 2.1. Өмнөх онд байгуулсан Захиргааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээг дүгнэх	2023 оны гэрээнээс дүгнэсэн тоо	3	1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд нийт 250, ажил, үйлчилгээний гэрээ баталгаажсанаас 2024 онд 191 гэрээг дүгнэж 2025 онд он дамжиж хийгдсэн 59 ажил байна. Үүнээс тайлант хугацаанд 22 гэрээг дүгнэж санхүүжилтийг олгосон. Мөн өмнөх онуудад байгуулагдсан гэрээний хугацаанд ажил гүйцэтгээгүй 3 компанид гэрээ цуцлах мэдэгдлийг хүргүүлсэн.	2025.01.02-2025.06.05	100%
5	Арга хэмжээ 2.2. Захиргааны гэрээ байгуулах чиглэлээр сумдын ЗДТГ болон төрийн байгууллагуудыг мэдээлэл арга зүйгээр хангах	Сум болон төрийн байгууллага албан тушаалтнаас ирүүлсэн гэрээний төсөл хянасан тоогоор	5	2	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2025 оны гэрээний төслийг боловсруулж холбогдох байгууллагуудаас гэрээнд тусгах саналыг авч нэгтгэн боловсруулсан гэрээний төслөөр гэрээ байгуулагдаж байна. Мөн Баян-Өндөр, Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээний төслийг хянан боловсруулсан. Үүнээс гадна Засаг даргатай байгуулах гэрээний төслийг хянаж хууль тогтоомжид нийцүүлэн гэрээг хянан баталгаажуулах ажлыг гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд Байгаль орчны газраас ирүүлсэн 5, ГХБХБГ-аас ирүүлсэн 2, ЭМГ-аас ирүүлсэн 2, хэлтэс нэгжүүдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, ажил гүйцэтгэх, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан тус	2025.01.02-2025.06.05	100%

					тус хянан баталгаажуулж ажилласан.		
6	Арга хэмжээ 2.3. Захиргааны гэрээг хуульд нийцүүлэн байгуулах, гэрээний гүйцэтгэлд хяналт тавих	Батлан гаргах гэрээний тоогоор	40	20	2025 оны эхний хагас жилээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэх 110, бараа худалдан авах 32, үйлчилгээ үзүүлэх 6, аваарын зардлаар ажил гүйцэтгүүлэх 10, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах 28, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах 30, ажил гүйцэтгэх сунгалтын 15, нэмэлт ажил гүйцэтгэх 2 гэрээг тус тус хянан баталгаажуулж ажилласан. Нийт 236 гэрээг хянан баталгаажуулсан байна.	2025.01.02-2025.06.05	100%
7	Арга хэмжээ 2.4 Гэрээний хэрэгжилтийн явц, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээ цуцлах нөхцлүүдийг удирдлагуудад танилцуулж тухай бүр шийдвэрлэх	Шийдвэрлэсэн асуудлын тоогоор	4	2	Гэрээний хэрэгжилтийн явц, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээ цуцлах нөхцлүүдийг удирдлагуудад танилцуулж тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Өмнөх онуудад байгуулагдсан гэрээний хугацаанд ажил гүйцэтгээгүй 3 компанид гэрээ цуцлах мэдэгдлийг хүргүүлсэн. Мөн баталгаат хугацаанд гэрээний үүргээ зөрчсөн 3 аж ахуй нэгжид шаардлага хүргүүлж ажилласан.	2025.01.02-2025.06.05	100%
Зорилт 3. ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГДӨХӨӨС, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХЭҮК БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
8.	Арга хэмжээ 3.1. Хүний эрхийг хангах чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллага, иргэдэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Сургалтад хамрагдсан иргэдийн тоогоор	40	40	Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран 2025 оны 05 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмыг таниулах үйл ажиллагааны талаар сургалт хэлэлцүүлгийг 2 өдөр зохион байгуулсан. Тус сургалт хэлэлцүүлэгт ЕБС-ийн 250 сурагч,	2025.01.02-2025.06.05	100%

					Их дээд сургууль, коллежийн 28 оюутан, 110 иргэн, захиргааны байгууллагын 34 төрийн албан хаагч, төрийн тусгай чиг үүрэгтэй 26 албан хаагч, ТББ-ын төлөөлөл болон үйлдвэрчний эвлэлийн хорооны 40 гишүүд нийт 448 хүн тус сургалтад хамрагдсан байна. Мөн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудад хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд хяналтын камер байрлуулсан байдал болон хурууны хээний бүртгэл зэргийг хянаж шалгах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.		
9.	Арга хэмжээ 3.2. Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгуулалатай хамтран ажиллах	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	4	2	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос эхний хагас жилд 2 зөвлөмж ирүүлсэн. Тус зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн үйл ажиллагаа, зарцуулсан төсөв болон 2025 онд төлөвлөсөн арга хэмжээ, зарцуулахаар тусгасан төсвийн талаарх мэдээллийг хуулийн хугацаанд гарган ХЭҮК-ын Тамгын газарт хүргүүлсэн. Мөн Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоог төлөвшүүлэх чиглэлээр гэрч хохирогчийг	2025.01.02-2025.06.05	100%

					хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучуудыг хөгжүүлэх, сэргээн засах, байнгын асаргаа шаардлагатай иргэдийг сувилах, ээжүүдийг чадавхижуулах, залуучуудыг дэмжих, сэтгэл зүйн цогц боловсрол олгох хүрээнд төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр аймгийн ЗДТГ 26 төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.		
10.	Арга хэмжээ 3.3. Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг хууль тогтоомж, журамд заасны дагуу тухай бүр мэдээллээр хангах, тайлан мэдээг гаргах	Мэдээ тайлан хүргүүлсэн тоо	2	1	Хүний эрхийг хангах Үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх” журам батлагдсан.Тус журмын дагуу тайланг дараа оны 01 дүгээр сард илтгэдэг бөгөөд 2024 оны тайланг 01 дүгээр сарын 21-ны өдөр Засаг даргын орлогч Д.Соёлчхүү ХЭҮК, ЗГХЭГ-т цахимаар тайлагнасан. 2025 оны тайлан мэдээг 4 дүгээр улиралд хүргүүлнэ.	2025.01.02- 2025.06.05	100%
Зорилт 4. “ЗАСАГ ДАРГА БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ, ШҮҮХЭД ТӨЛӨӨЛӨХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
11.	Арга хэмжээ 4.1. Аймгийн Засаг даргаас нутгийн өөрөө удирдах байгууллага буюу ИТХ, ИТХТ-ийн хуралдаанд оруулах	Батлан гаргасан актын тоогоор	40	28	Аймгийн Засаг даргын хөрөнгө гаргах тухай захирамж 1, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд	2025.01.02- 2025.06.05	100%

	шийдвэрийн төсөл, аймгийн Засаг даргын захирамжийн төсөл, худалдан авах ажиллагааны гэрээний төслийг хянаж, санал дүгнэлт өгөх, хууль зүйд нийцүүлж гаргахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх				төлөөлөх тухай 4 захирамжийг тус тус боловсруулж батлуулсан. Мөн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 14/03 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн түвшинд үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц байдлыг аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Төрийн байгууллагуудаас гаргаж буй 2 дүрэм журам, Засаг даргын 3 захирамжийн төслийн хуулийн үндэслэлийг хянаж санал дүгнэлт өгсөн. 2025 оны эхний хагас жилээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэх 110, бараа худалдан авах 32, үйлчилгээ үзүүлэх 6, аваарын зардлаар ажил гүйцэтгүүлэх 10, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах 28, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах 30, ажил гүйцэтгэх сунгалтын 15, нэмэлт ажил гүйцэтгэх 2 гэрээг тус тус хянан баталгаажуулж ажилласан. Нийт 236 гэрээг хянан баталгаажуулсан байна.		
12.	Арга хэмжээ 4.2. Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	Шүүхийн хэргийн тоогоор	4	2	Аймгийн Засаг даргыг төлөөлж нийт 6 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон ба 1 хэргийг эцэслэн шийдвэрлэж бусад хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Ажиллагаанд байгаа хэргээс Иргэний хэргийн 1, захиргааны хэргийн 5 байна. Мөн аймгийн	2025.01.02-2025.06.05	100%

					Засаг даргыг төлөөлөн иргэний хэргийн шүүхэд 2 нэхэмжлэл гаргасан.		
Зорилт 5. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
13.	Арга хэмжээ 5.1. Иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх	Өргөдөл гомдол шийдвэрлэсэн тоо	4	3	Аймгийн Засаг даргын Тамгын газар өргөдөл гомдол хүлээн авах төвд ирсэн 3, Засгийн газрын 11-11 төвд ирсэн 1, хууль эрх зүйн хэлтсийн даргад бичгээр өгсөн 2 өргөдөл гомдолыг тухай бүр нь хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн. Нийт 6 өргөдөл гомдолыг шийдвэрлэж ажилласан.	2025.01.02- 2025.06.05	100%
14.	Арга хэмжээ 5.2. Аймгийн ИТХ, Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах	Ажлын хэсэгт ажиллсан тоо	3	2	Хангал гүүрний төлбөр хураах цэгийг Жаргалант суманд байрлах төлбөр хураах цэгээр Орхон аймгийн улсын дугаар бүхий тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжийг судлаж цагаан жагсаалтад бүртгүүлэх, тендерийн үйл ажиллагаанд хяналт тавих, гүйцэтгэлийн санхүүжилтийн баримт бичгийн бүрдлийг хангуулах үйл ажиллагааг цахимжуулах, орон сууцны байрнуудын подвалд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжүүдэд хяналт, шалгалт хийх, “Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд, шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах, зөвшөөрөл олгох, хугацаа сунгах журам”-ын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх комисс зэрэг Аймгийн Засаг даргын 2, Баян-Өндөр сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан 1, Аймгийн ИТХ-ын даргын баталсан 1	2025.01.02- 2025.06.05	100%

					ажлын хэсэгт нарийн бичиг болон гишүүнээр ажилласан. Мөн төрийн албан хаагчдын хойд бүсийн бүсчилсэн хөгжил, төрийн албаны манлайлал зөвлөгөөн, 2025 оны эдийн засгийн форум зохион байгуулах ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулагдсан 2 ажлын хэсэг нийт 6 ажлын хэсэгт ажиллаж өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж ажилласан.		
15.	Арга хэмжээ 5.3. Засаг даргын шуурхай зөвлөгөөн болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх	Үүрэг даалгаврын ирсэн тоо	2	2	Засаг даргын шуурхай зөвлөгөөн болон удирдлагаас өгсөн 13 үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд биелүүлж тухай бүр тайлан мэдээг тайлагнасан.	2025.01.02-2025.06.05	100%
16.	Арга хэмжээ 5.4. Нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон авилгын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх хэрэгжилтийг хангах /гэрээнд тусгах/	Батлагдсан гэрээний тоогоор	50	25	Хөрөнгө оруулалтын болон хамтран ажиллах гэрээний талуудын эрх үүрэгт нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авилгын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хууль зөрчихгүй, авлигаас ангид ажиллах үүрэг хүлээхээр тусгасан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэх 110, бараа худалдан авах 32, үйлчилгээ үзүүлэх 6, аваарын зардлаар ажил гүйцэтгүүлэх 10, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах 28, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах 30, ажил гүйцэтгэх сунгалтын 15, нэмэлт ажил гүйцэтгэх 2 гэрээг тус тус хянан баталгаажуулж ажилласан. Нийт 236 гэрээг хянан баталгаажуулсан байна.	2025.01.02-2025.06.05	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 2.1. Хууль, эрх зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэх	Мэргэжлийн ур чадвар, мэдлэг дээшлүүлэх сургалтад хамрагдсан тоо	2	1	Аймгийн ЗДТГ болон холбогдох бусад байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад оролцож ажилласан. Тухайлбал, Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын хэрэгжилт, үр дүн, Хүний эрхийн Үндэсний комиссоос зохион байгуулсан хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмыг таниулах, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг 4 удаагийн сургалтад тус тус оролцсон	2025.01.02-2025.06.05	100%
2	Арга хэмжээ 2.2. Ёс зүй, харилцаа хандлага болон бусад сургалтад хамрагдах		2	1	ТАЗ-өөс зохион байгуулж буй сургалтууд болон байгууллагын ёс зүйн хорооноос зохион байгуулсан сургалтад тухай бүр оролцсон.	2025.01.02-2025.06.05	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНИЙ ЭРХ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГЭРЭЭ ХЭЛЦЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.НОМИН-ЭРДЭНЭ / *Б.Номин-Эрдэнэ* /

2025.06.05

(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

(Огноо)